



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/26/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас:9907-9641 Цахим хаяг: Tserenlkhambg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2022.09.24 № 601

танай _____ ны № _____ т

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ЦОЛМОНБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшууллыг байгууллагын дарга эрх зүйн шийдвэргүй 10 хувь, нягтлан бодогч 1 сарын цалингаар нийт 1.8 сая, 5 албан хаагчдад цалинтай чөлөөний хугацаанд нөхөх төлбөр 0.1 сая, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 албан хаагчдад шийдвэргүйгээр 1-2 хувиар нэмэгдүүлэн 1.2 сая, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ илүү цаг ажиллаж хэрэгжүүлэн 4 албан хаагчдад 1.4 сая төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг нийт 115.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөө нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 45 дугаар зүйлийн 45.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйлийн 13.1, 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.4, Төрийн албаны тухай хуулийн

632805023

51 дүгээр зүйлийн 51.3, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оныг "Багшийн ёс зүйн жил" болгон зарлаж, багш нарын ёс зүйг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах талаар ажилласан байна. Мөн багш нарын мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг сайжруулах, тэдний нийгэм дэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой дэвшүүлэн ажиллажээ.

Бусад асуудал

Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээд сургуулиудыг их сургууль эсвэл коллеж гэсэн ангилалд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хугацааг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл байхаар хуульчилсан. Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	78,257.8	95,536.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	544,701.6	492,701.4
	Нийт хөрөнгийн дүн	622,959.4	588,238.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	8,293.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	622,959.4	579,944.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	622,959.4	588,238.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	7,125,674.3	5,348,881.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	7,030,490.5	5,383,940.1
	Үйл ажиллагааны үр дүн	95,183.8	(35,058.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(22,139.8)	(7,956.5)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	73,044.0	(43,014.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	929,405.9	912,647.0
	Тайлант оны үр дүн	(16,758.9)	(432,176.1)
	Эцсийн үлдэгдэл	912,647.0	480,470.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,834,087.4	5,334,720.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,716,564.1	5,330,520.7
	Үйл ажиллагааны ЦМГ	117,523.3	4,200.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(117,527.3)	(4,200.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(4.0)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4.0	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	4,976,743.5
	Урсгал зардал	-	4,976,743.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	4,976,743.5
	Улсын төсвөөс санхүүжих	-	4,976,743.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын газар нь эрхэм зорилгоо “Шинийг сэтгэж, Шинэчлэлд хамтдаа” гэж тодорхойлон, 2025-2026 оны хичээлийн жилд “Багшлахуйг хөгжүүлэх, ээлжит хичээлийн бэлтгэл үр өгөөжийг нэмэгдүүлэн, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ” хэмээн зорьж ажиллаж байна.

Үйл ажиллагааны ерөнхий зорилгоо “аймаг, дүүргийн хэмжээнд боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ЕБС, СӨБ болон МСҮТ-ийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, чанартай боловсролын үйлчилгээг иргэн бүрт тэгш хүргэх” гэж дэвшүүлжээ.

Улсын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, Сургалтын байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, ЕБС, СӨБ, МСҮТ-ийн үйл ажиллагаанд тогтмол хяналт-шинжилгээ хийх, Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжил, чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, Шинэчилсэн хөтөлбөр, арга зүйг сургуулиудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэгт хүүхдийн эрхийг хангах нөхцөл бүрдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээтэй хүүхдэд боловсролын тэгш боломж олгох үйл ажиллагаа зохион байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч үнэлгээ хийгдээгүй байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын газар нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаа явуулдаг байна.

Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын баталсан журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн хууль;

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газрын хяналт, шинжилгээний үнэлгээний газраас санхүүгийн тайлан болон үйл ажиллагаанд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээд сургуулиудыг их сургууль эсвэл коллеж гэсэн ангилалд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хугацааг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл байхаар хуульчилсан. Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Тав. Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оныг "Багшийн ёс зүйн жил" болгон зарлаж, багш нарын ёс зүйг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах талаар ажилласан байна. Мөн багш нарын мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг сайжруулах, тэдний нийгэм дэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой дэвшүүлэн ажиллажээ.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс бүрэн мэдээлсэн байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын албан тоот, тушаал гэх мэт хэвлэмэл болон улсын байцаагчийн үнэт цаасыг бодитоор тоолж, тайланг хариуцсан ажилтнаар гаргуулж хэвших зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Баян-Агт сумын Хануй рашаанд “Багш амралт”-ын газрыг зуны улиралд ажиллуулж, 6.0 сая төгрөгийн орлогыг нярав хувийн харилцах дансанд төвлөрүүлж, амрагч нарт төлбөрийн баримт олгоогүй, өөрийн орлогыг бүрэн төвлөрсөн эсэхийг нотлохгүй байна.
2. Бараа материалын тайланд бичиг хэргийн материал дансанд 9 нэр төрлийн аж ахуйн материал, Барилгын засварын материал дансанд агааржуулалтын хоолой, гүйдэг машины хаалга, жижиг хаалга, цэцгийн булангийн төмөр тавиур 4 нэр төрлийн эргэлтийн бус хөрөнгө бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн тайлангийн дансны ангилал зөрүүтэй байна.

Дараагийн аудитаар амралтын газрын орлогыг бүрэн төвлөрүүлж байгаа эсэх, бараа материал болон үндсэн хөрөнгийн дансны ангиллыг стандартын дагуу бүртгэсэн эсэхийг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 18.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 18.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 120.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 115.5 төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 120.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 66.0 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Аудитаар албан хаагчийг илүү цагаар ажиллуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр байхгүй, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан албан хаагчид 1.4 сая төгрөгийн илүү цаг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тушаалаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрүүтэй тооцож олгосон илүү цагийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 2: Аудитаар нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон байхад албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан үр бүтээл гаргасан гэдгийг нотлох баримт байхгүй, "өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажилласан гэх үндэслэлээр нягтлан бодогч 1 сарын үндсэн цалин 1.6 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрүүтэй тооцож, давхардуулан олгосон зөрчиж олгосон урамшууллыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 3: Тайлант жилд цалинтай чөлөө олгосон 5 албан хаагчид цалингийн зардлаас хоол, унааны мөнгө 60.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

төлбөр олгох журам", нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинтай чөлөө авсан 5 албан хаагчид олгосон хоол, унааны мөнгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Албан шаардлага

Илрүүлэлт: Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 албан хаагчдад эрх зүйн шийдвэргүйгээр 1-3 хувиар нэмэгдүүлэн 1.2 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа удирдах", 16.5.5-д "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 115.2 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг дутуу тооцсон.	1	0.3	1	0.3			1	0.3				
Сангийн яамнаас авах авлагыг дутуу тооцоо нийлсэн.	1	18.2	1	18.2			1	18.2				
Дүн	2	18.5	2	18.5			2	18.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчийг илүү цагаар ажиллуулах эрх бүхий албан	1	1.4	1	1.4								

төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.	3	119.6	3	3.2	1	1.2	1	115.2				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй байна.	1	-				1
Дүн	1	-				1
Нийт дүн	1	-				1